



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 04 дүгээр сарын 18
№16 (1361)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|--|-----------|-----|
| 77. | Авлигатай тэмцэх газрын даргыг
улируулан томилох тухай | Дугаар 33 | 803 |
| 78. | Үндсэн хуулийн цэцийн 2025 оны
02 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 34 | 805 |

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

- | | | | |
|-----|--|-----------|-----|
| 79. | Монгол Улсын шүүхийн тухай хуулийн
47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн
холбогдох зохицуулалт Монгол Улсын
Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 02 | 807 |
|-----|--|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар 33

Улаанбаатар
хот

Авлигатай тэмцэх газрын даргыг улируулан томилох тухай

Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын даргаар Зандраагийн Дашдавааг улируулан томилсугай.

2. Энэ тогтоолыг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

Бүтээгдэхүүн бүхий үйлчилгээний үйлдвэр

Бүтээгдэхүүн бүхий үйлдвэр

Хүний нөөц

2025 он 10 сарын 1-н өдөр - 10 сарын 10-н өдөр

Бүтээгдэхүүн бүхий үйлчилгээний үйлдвэр
Бүтээгдэхүүн бүхий үйлдвэр

Бүтээгдэхүүн бүхий үйлчилгээний үйлдвэр 2025 он 10 сарын 1-н өдөр
Бүтээгдэхүүн бүхий үйлдвэр:

6. Бүтээгдэхүүн бүхий үйлчилгээний үйлдвэр 2025 он 10 сарын 1-н өдөр

7. Бүтээгдэхүүн бүхий үйлчилгээний үйлдвэр 2025 он 10 сарын 1-н өдөр

Бүтээгдэхүүн бүхий үйлдвэр
Бүтээгдэхүүн бүхий үйлдвэр

Бүтээгдэхүүн бүхий үйлдвэр

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр
сарын 04-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... нас ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс ... нийгэм, хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

[illegible]

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 02 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 02

Улаанбаатар
хот

**Монгол Улсын шүүхийн
тухай хуулийн 47 дугаар зүйлийн
47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт
Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Э.Энхтуяа /илтгэгч/, Р.Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн О.Баясгалан болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нар оролцов.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын иргэн О.Баясгалан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл гаргасан байна. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн нь Үндсэн хуульд нийцэхгүй байна. Шүүгчийн албан тушаалд 30 ба түүнээс дээш жил ажилласан мөн 55 насанд хүрсэн шүүгчийг өндөр насны тэтгэвэр тогтоолгоно гэж хуульчилснаас үүдэн өөрөөс нь үл хамаарах шалтаг, үндэслэлээр түүний хүсэлтийг харгалзахгүйгээр



захиргааны албадлага хэлбэрээр хөдөлмөрлөх эрхийг хязгаарлан шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх хууль зүйн үндэслэл бүрдүүлжээ. Мөн 25 насанд шүүгч болсон бол 55 насанд тэтгэвэр тогтоолгох нөхцөл бий болсон байна.

Шүүгчийн хараат бус байдал, түүний агуулгын бүрэлдэхүүн хэсгийн тэргүүн зэрэгт шүүгч эрх зүйн байдлын хувьд хараат бус, ялгаварлалгүй байх асуудал эрэмбэлэх бөгөөд энэ нь эрх зүйт төртэй улс орнуудад түгээмэл тогтоосон ойлголт юм. Энэ утгаараа шүүгч хугацаагүй томилогддог жишиг тогтсон юм. Нөгөөтээгүүр энэ байдал нь 25 настайдаа, мөн түүнээс хойш насандаа томилогдсон шүүгч, түүнчлэн шүүгчээр өмнө ажиллалгүйгээр Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдсон шүүгчдийн хооронд шүүгчээр ажилласан хугацаа, шүүгчийн наснаас нь хамаарч илэрхий ялгавартай байдал үүсгэж буй нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй нийцэхгүй, тэдгээрийг зөрчсөн байна.

Мөн Үндсэн хууль хэлэлцэх үед шүүгчийг бүх насаар нь эсвэл төрийн албан хаагчийн хувьд тэтгэвэр тогтоолгох нас хүртэл гэсэн хоёр үзэл баримтлал явж улмаар төрийн албаны насны дээд хязгаар гэсэн ойлголтод хүрч Үндсэн хуульд туссан байхад хууль тогтоогч анхаараагүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.” гэж хуульчилсан.

Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтад “төрийн тусгай алба;”, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “төрийн тусгай албан тушаал;”, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараахь албан тушаал хамаарна:” гээд 13.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;” гэж заажээ. Төрийн албаны тухай хуулийн нийтлэг зохицуулалтаас тусад нь шүүгч гэж авч үзэж буй нь төрийн албанаас

шүүхийг тусгайлан ялгаварлаж шүүхийн баталгааг алдагдуулсан байна. Түүнчлэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар бүх хүнд адил тэгш тавигдах шаардлагыг агуулгынх нь хэмжээнд өргөжүүлэн, бусад иргэдээс ангид үзэж шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулж байгаа нь Үндсэн хууль зөрчсөн нэмэлт болзол тавьсан, олон жил шүүгчээр ажилласан туршлага дадлыг үгүйсгэсэн, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг таван жилээр богиносгожээ.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

Хуралдаанд бэлтгэх явцад иргэн О.Баясгалангийн мэдээллийн шаардлагад дурдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсон бөгөөд 2023 онд батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д адил зохицуулалт ороогүй болохыг тэмдэглэж байна.

Хоёр. Монгол Улсын иргэн Н.Ариунболд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл ирүүлжээ. Үүнд:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтад “өндөр наслах ... тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй,” гэж заасан эрхийн харилцааны заримыг нийгмийн даатгал буюу тэтгэврийн даатгалын эрх зүйн харилцаагаар зохицуулдаг. Тодруулбал, Нийгмийн даатгалын тухай хуульд зааснаар нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол журмын дагуу шимтгэл төлж нийгмийн даатгалд даатгуулсан иргэн хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй байдаг. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд зааснаас үзэхэд Монгол Улсад өндөр насны тэтгэвэр авах эрхийн насны дээд хязгаар 65 гэж ойлгогдож байна. Харин Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтад зааснаар ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүссэн бол хөдөлмөрийн гэрээг ажил оллогчийн санаачилгаар цуцлах тухай заасан.

Шүүгч нь ажил хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа иргэний хувьд Үндсэн хууль, Нийгмийн даатгалын тухай хуульд заасанчлан өндөр насны тэтгэвэр авах эрхтэй. Мөн шүүгчийн өндөр насны тэтгэвэртэй холбоотой харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиас өөрөөр Монгол Улсын шүүхийн тухай хуульд заажээ. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47



дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь шүүгчийн тэтгэвэрт гарах дээд нас 60 боловч мөн хэсэг дотроо шүүгчийн тэтгэвэрт гарах дээд насыг шүүгчээр ажилласан жилтэй нь холбон 55 нас гэж тус тус өөрөөр заажээ. Мөн хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.9 дэх заалтад зааснаар шүүгч өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн бол өөрөө хүссэн эсэхээс үл хамааран Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож, чөлөөлөхөөр заасан байна. Өөрөөр хэлбэл, шүүгчээр 30 жил ажиллаад 55 нас хүрсэн бол шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас хүрсэн эсэхээс үл хамааран шүүгчийг чөлөөлж буй хэм хэмжээ нь Үндсэн хуульд нийцэхгүй байна.

Нийгмийн даатгал, хөдөлмөрийн эрх зүйн харилцаагаар иргэн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн бол нэг тал (ажил олгогч)-ын санаачилгаар, хэрэв уг насны дээд хязгаарт хүрээгүй бол иргэн (ажилтан) зөвхөн өөрийн хүсэлтээр тэтгэвэрт гарах хэм хэмжээ үйлчилдэг. Гэтэл шүүгчээр ажиллаж байгаа иргэнийг тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрэхээс өмнө өөрөө хүсэлт гаргаагүй байхад шүүгчээр 30 жил ажилласан, 55 нас хүрсэн үндэслэлээр шүүгчийн албан тушаалаас чөлөөлөхөөр заасан нь хуулийн өмнө эрх тэгш байх, нийгмийн байдал, эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлаж үл болох Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг ... нийгмийн ... байдал, ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 5 дахь заалтад “өндөр наслах ... тохиолдолд ... тусламж авах эрхтэй.”, Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.” гэснийг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү.” гэсэн байна.

Гурав. Уг маргаанд холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ирүүлсэн тайлбарт:

3.1.Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчөөр томилогдсон Улсын Их Хурлын гишүүн асан Ж.Сүхбаатар Үндсэн хуулийн цэцэд өмнө ирүүлсэн тайлбартаа:

“1. ... Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.” гэж зааснаар шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гаргах хүртэл нь хугацаагүй томилох, халж солихгүй байх Үндсэн хуулийн зарчмыг бэхжүүлсэн. Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох, тэтгэврийн насанд хүрч албан тушаалаас чөлөөлөгдөх үндэслэл журмыг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д тусган батлахдаа Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн баталсан. Ингэхдээ шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг 60 нас байхаар, шүүгчээр 25 жил ажилласан, эсхүл 55 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор заасан 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн орчинг уламжлан хадгалсан тул эрх зүйн байдлыг дордуулсан гэж дүгнэсэн нь үндэслэлгүй юм. Харин маргаан бүхий заалт болох 30, түүнээс дээш жил тасралтгүй ажилласан бол тэтгэвэр тогтоолгох насны дээд хязгаарыг 5 жилээр богиносгон 55 насанд хүрснээр өндөр насны тэтгэвэр тогтоолгох боломжийг шүүгчид олгосон нь шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулсан гэхээс илүүтэй шүүгчийн үйл ажиллагаа, ажил мэргэжлийн онцлогтой холбоотойгоор уг зохицуулалтыг бий болгосон. Шүүгч нь шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ оролцогч талуудад тэгш хандах, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримтлан, хууль хэрэглэж, шударга ёсыг тогтоох, хүн бүр эрх чөлөөгөө баталгаатай эдлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн тогтооход оршдог. Шүүгчийн энэ амаргүй хүнд хөдөлмөрийг мэргэжлийн болон ур чадварын, ёс зүйн өндөр түвшинд тасралтгүй, нөлөөнд орохгүйгээр алдаагүй гүйцэтгэх нь хөдөлмөрийн ердийн нөхцөл, боломжоос давсан хүчин чармайлтыг хувь хүнийх нь хувьд шаардана. Шүүгчээр тасралтгүй ажиллах цаг хугацааны бодит боломж, бүтээмж, нийгмийн хөгжлийн хурд болон бусад хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлага гарч ирж байгаа юм. Хууль тогтоогч энэ бүх байдлыг анхааран үзэж, шүүгчийн тэтгэврийн харилцаатай холбоотой асуудлыг зохицуулан хуульчилсан.

Хэрэг маргааны ээдрээ төвөгтэй байдал, хууль хэрэглээний нарийн асуудлуудад алдаа эндэгдэл гаргахыг үгүйсгэхгүй. Хүний сонголтод ч алдахгүй байх бүрэн төгс шийдэл бий болоогүй байна. Европын шүүгчдийн зөвлөлдөх зөвлөлийн зөвлөмжид зааснаар европын улс орнууд шүүгчдийг туршилтын хугацаагаар томилж байна.



2.Тэгш эрхийн зарчим нь хууль зүйн утгаараа бусдад адил тэгш хандах, адилхан стандарт баримтлах ойлголтыг илэрхийлдэг ба тодруулбал яг ижил нөхцөл, эсхүл тохиолдолд эрх зүйн үйлчлэл чиглэх субъектэд хуулийн заалтыг ижил хэрэглэнэ, адил шийдвэр гаргах агуулгаар ойлгоно. Хууль тогтоогч 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн 55 настайдаа тэтгэвэр тогтоолгох заалтыг шүүгчээр 30 жил тасралтгүй ажиллах гэсэн нөхцөлтэй хамт хэрэглэхээр, харин 60 настай өндөр насны тэтгэвэр тогтоолгох харилцаанд ажилласан жилийн дээрх нөхцөлийг хэрэглэхгүйгээр зөвхөн насны шалгуурыг тогтоон хуульчилсан тул шүүгчид ялгаатай хандсан гэж үзэх боломжгүй юм.

... Шүүгч төрийн албан хаагчийнхаа хувьд Төрийн албаны тухай хуулийн нийтлэг зохицуулалтад хамаардаг хэдий ч албан тушаалын дээрх онцлог байдлаас хамаарч тусгай болзол нөхцөл, эрхийн хамгаалалт, зохицуулалтыг шаарддаг. Энэ байдлыг харгалзан Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хоорондын уялдаа, хамаарлыг тогтоон хуульчилсан. Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны дээд хязгаар 65 нас гэснийг бусад хуульд өөрөөр тогтоож болохыг зөвшөөрсөн тул иргэний мэдээлэлд дурдсанчлан “Төрийн албаны хуулиас ялгавартай тогтоосон” зөрчил үүсгээгүй гэж үзэж байна. ...” гэжээ.

3.2.Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт тайлбартаа:

“1. ... Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-аар шүүхийн бие даасан, хараат бус байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлэн Үндсэн хууль болон хууль тогтоомжийн түвшинд эрх зүйн үндэслэл бүхий зохицуулалтуудыг боловсруулан баталсан. Шүүгч нь төрийн албан хаагчийн хувьд төрийн албаны нийтлэг зохицуулалтад хамаардаг хэдий ч албан тушаалын онцлог байдлаас хамаарч тусгай болзол, нөхцөл, эрхийн хамгаалалтыг шаарддаг. Шүүгчийн өөрийн үйл ажиллагаа болон ажил мэргэжлийн онцлогтой холбоотойгоор уг хууль болон Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хоорондын уялдаа, хамаарлыг тогтоон хуульчилсан болно. Түүнчлэн ажлын нөхцөл, аюулгүй байдал, онцлог, нийгмийн бодлого зэргээс хамаарч мэргэжил бүр өндөр насны тэтгэвэрт гарах, тогтоолгох өөр өөр насны ангилалтай байдаг:

Цагдаагийн албаны тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.1-91.1.5 дахь заалтад заасанчлан цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан үндэслэлээр цагдаагийн алба хаагч тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авах эрхтэй бөгөөд алба хаах насны дээд хязгаар нь цагдаагийн бага цолтой алба хаагч 47 нас; цагдаагийн дунд цолтой алба хаагч 52 нас; цагдаагийн ахлах цолтой алба хаагч 55 нас; цагдаагийн дээд цолтой алба хаагч 57 нас; цагдаагийн бага цолтойгоос бусад эмэгтэй алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар нь 47 нас байна. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн зорилт нь зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүх шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч нь дор дурдсан үндэслэлээр нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.” гээд 1 дэх заалтад “25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй;”, 2 дахь заалтад “20-оос доошгүй жил алба хаасан эмэгтэй;”, 3 дахь заалтад “байлдааны нисдэг тэрэгний нисгэгчээр 23-аас доошгүй жил цэргийн алба хаасан;”, 4 дэх заалтад “байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисгэгчээр 20-оос доошгүй жил цэргийн алба хаасан.” гэж тус тус заасан.

Прокурорын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Прокурорын тэтгэвэрт гарах насны дээд хязгаар нь 60 нас байх ба 50 насанд хүрсэн эмэгтэй, 55 насанд хүрсэн эрэгтэй, эсхүл нас харгалзахгүйгээр прокуророор 25 жил ажилласан прокурор өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.” гэж; Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцийн гишүүн Төрийн албаны тухай хуульд заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу Цэцийн гишүүний албан тушаалаас чөлөөлөгдөж болно.”, 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүнийг насны тэтгэвэрт гарах үед нь Цэцийн гишүүний цалингийн 60 хувиар бодож тэтгэвэр тогтоож болно. Тэтгэврийг нийгмийн даатгалын сангаас олгоно.” гэж хуульчилжээ.

2. ... Олон улсын жишиг хандлагаас харахад шүүгчийн бүрэн эрхийн хугацааг хараат бус байхын баталгаа болох бүх насаар нь томилох, эсхүл хугацаатай томилох, түүнчлэн тэтгэврийн насаар нь хязгаарлаж байна. “Шүүхийн бие даасан байдлын талаарх НҮБ-ын суурь зарчмууд”-ын 11 дэх хэсэгт “Шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа, тэдний хараат бус байдал, хүрэлцэхүйц хэмжээний цалин, тэтгэвэр тэтгэмж, тэтгэвэрт гарах насны хэмжээ нь хуулиар хамгаалагдсан байна.” гэж заажээ. Шүүгчийн тэтгэврийн нас тодорхой байгаа нь шүүхийн онцгой шаардлага, хариуцлагыг



тодорхойлдог. Эдгээр заалтууд нь зөвхөн захиргааны шийдвэр биш, харин шүүхийн хараат бус байдлыг хадгалах, туршлагыг ашиглах, хууль эрх зүйн тогтолцооны бүрэн бүтэн байдлыг хангахын салшгүй хэсэг юм. Шүүхийн албыг мэргэжлийн онцлог шаардлагуудтай уялдуулах замаар нийгэм нь шүүхүүдээ шударга ёс, шударга ёсны тулгуур багана хэвээр үлдээж, хувьсан өөрчлөгдөж буй сорилтод дасан зохицож, тогтвортой зарчмуудыг баримтлах чадвартай байхыг баталгаажуулдаг.

Тэтгэврийн төрөлжсөн насны өөр нэг үндэслэл нь шүүх эрх мэдлийн шинэтгэл, залгамж чанарыг тэнцвэржүүлэх шаардлага юм. Туршлагатай шүүгчдийг авч үлдэх нь тогтвортой, тууштай байдлыг хангахын зэрэгцээ заавал тэтгэвэрт гарах нас нь шинэ томилгоо хийх боломжийг бүрдүүлдэг. Энэхүү тэнцвэр нь шүүхийн тогтолцооны олон талт байдал, инновац, дасан зохицох чадварыг хөгжүүлж, өөрчлөгдөж буй хууль эрх зүйн орчинд тэдгээр нь хамааралтай, үр дүнтэй хэвээр байх боломжийг олгодог. Ротаци хийх шүүхийн хэрэгцээ, шүүхийн шударга ёсны зайлшгүй шаардлагыг тэнцвэржүүлэхийн тулд заавал тэтгэвэрт гарах насыг ялгамжтай байдлаар тодорхойлж, шүүхийн гүйцэтгэх үүргийн өвөрмөц шаардлага, хязгаарлалтыг тусгаж, шүүгчийн бүрэн эрхийн хугацаанд болон дараа нь улс төрийн дарамт шахалт үзүүлэхээс урьдчилан сэргийлэх шаардлага үүсдэг болно.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2024 оны №01/1185 дугаар албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбарт:

“1.2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрөөс Шүүхийн ерөнхий зөвлөл 10 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас ...” гэснийг хэрхэн ойлгож хэрэглэх асуудлыг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн байна.

Уг хуралдаанаар “... 1997 онд батлагдсан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт ороогүй нөхцөл байдал болон уг хууль болон шүүхийн тухай хуулийн аль алиныг сонгож хэрэглэх боломжтой байдлаар шийдвэрлэж байсан өмнөх жишгийг үргэлжлүүлэн хэрэглэх нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх заалтын агуулгад нийцнэ гэж үзсэн. 1997 онд батлагдсан “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн даатгалын халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль”-д 2017, 2018 онд нэмэлт, өөрчлөлт оржээ. Уг нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан эрэгтэй шүүгч нар өндөр насны тэтгэвэрт гарах насыг 61 нас хүрснээр тооцох хүсэлтийг урьдах Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүгч нараас ирүүлснийг дээрх хуульд нийцүүлэн 2021 оноос шийдвэрлэж ирсэн байдаг.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр дээр дурдсан 1997 оны хууль хүчингүй болсон. Үүнтэй холбогдуулан “шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаар” гэснийг цаашид хэрхэн ойлгож хэрэглэх талаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт буюу 60 нас хүрсэн шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэхээр өргөн мэдүүлж эхэлсэн болно. Шүүгчийг “тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүрсэн” гэсэн үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлүүлэхээр өргөн мэдүүлэхэд өөрөөс зөвшөөрөл авсан байхыг шаардахгүй бөгөөд энэ нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.9 дэх заалтад нийцэж байгаа.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “... 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. ...” гэсэн зохицуулалт Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль /2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар орсон нэмэлт, өөрчлөлт/-аар зохицуулж байсан. Дээрх үндэслэлээр шүүгчээс ирсэн хүсэлтийг үндэслэн албан тушаалаас нь чөлөөлүүлэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлснийг хүлээн авч зарлиг гаргасан байна.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн зохицуулалт энэ хуульд анх удаа орсон. Шинэ хуулийн энэ зохицуулалтыг хэрхэн ойлгож хэрэглэх асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын



31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Уг хуралдаанаар “... шүүгч хүсэлт гаргаагүй тохиолдолд ... шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн ... гэсэн үндэслэлээр шүүгчийг чөлөөлүүлэхээр өргөн мэдүүлэх боломжгүй ...” гэж олонхын саналаар шийдвэрлэхдээ дараах үндэслэлүүдийг баримталсан:

а.Хуулийн энэ заалт “... 25-30 хүртэл настайдаа томилогдсон ...” шүүгч нарын бүрэн эрхэд хугацаа тогтоосон байдлаар хэрэгжихээр байгаа нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “... шүүгч ... хугацаагүй ...” томилогдох баталгааг хөндөж байгаа;

б.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн ...” гэсэн хоёр урьдчилсан нөхцөлийн аль нэг нь бий болохгүй тохиолдолд уг заалт хэрэгжих боломжгүй;

в.Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийг хүний нөөцөөр хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.3 дахь заалтад заасны дагуу “... шүүгчийг ... албан тушаалаас нь чөлөөлүүлэх тухай саналыг Ерөнхийлөгчид хүргүүлэх ...” бүрэн эрхтэй ч энэ нь 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх заалтад заасан үндэслэлээр хязгаарлагддаг;

г.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.2-40.2.9 дэх заалтад мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн ...” үндэслэлийг заагаагүй;

д.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн ...” тохиолдол ороогүй тул мөн зүйлийн 32.2.1 дэх заалтад “... тогтоолгох бол ... Ерөнхий зөвлөлд мэдэгдэх ...” гэдэгт шүүгч, түүний гэр бүлийн гишүүний нийгмийн баталгааны талаарх 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “... тогтоолгоно ...” гэснийг хамааруулах нь мөн хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.1 болон 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “... захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй ... байх;” гэснийг зөрчихөөр байгаа юм. ...” гэсэн байна.

Дөрөв. Мэдээлэл, маргааныг урьдчилан шалгах болон Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх хүрээнд дараах баримт бичиг, тайлбар, шийдвэр, судалгаа, эх сурвалжтай танилцаж, холбогдох эрх бүхий этгээдээс баримт, тайлбар, дүгнэлт, лавлагааг гаргуулан авсан болно:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр (Цэцийн магадлал, дүгнэлт, тогтоол);

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, “Баримт бичгийн хуулбар хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.06.18, №ТГ-02/1023, 2021 оны Монгол

Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцсэн Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл, төслийн үзэл баримтлал, холбогдох судалгаа, тайлан;

Монгол Улсын Их Хурал /цаашид “МУИХ” гэх/-ын 2020 оны хаврын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны /цаашид “ХЗБХ” гэх/ хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, 2020.04.15;

МУИХ-ын 2020 оны намрын ээлжит чуулганы ХЗБХ-ны хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, 2021.01.05;

МУИХ-ын 2020 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, 2021.01.07; 2021.01.08; 2021.01.13; 2021.01.14;

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөл, “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг, 2021.03.11, №01/235; “Тайлбар, мэдээлэл, судалгаа хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.07.01, №01/1185;

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс томилсон шинжээч Г.Цагаанбаяр, “Шинжээчийн дүгнэлт”, 2024.10.08;

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл, 2016;

Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын Ерөнхий Ассамблейн тогтоол, 1948, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, 217/A/III/;

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол, 1966, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, 2200A(XXI);

НҮБ-ын Долоодугаар Их Хурал, Шүүхийн бие даасан байдлын талаарх Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь зарчим, 1985;

НҮБ-ын Шүүхийн шударга байдлыг бэхжүүлэх хуульчдын баг, Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим, 2002;

НҮБ-ын Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Бангалорын зарчмын тайлбар, 2010;

Шүүхийн хараат бус байдлын тухай дэлхийн хурал, Шүүхийн бие даасан байдлын талаарх түгээмэл тунхаглал (Монтреалын тунхаглал), 1983;

НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар, Үл ялгаварлан гадуурхалт, 1989, №18; Шүүх, маргаан таслах байгууллагын өмнө тэгш байх, шударгаар шүүлгэх эрх, 2007, §14, №32;

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төв, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн зохицуулалтад холбогдох гадаад орны харьцуулсан судалгаа, 2024.10.24.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.”



гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-ийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох зохицуулалтыг тус тус зөрчсөн эсэх маргааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (цаашид “Үндсэн хуулийн цэц” гэх)-ийн дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэхэд дараах үндэслэл тогтоогдож байна:

1.Шүүх эрх мэдэл нь хүний эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалсан хувийн болон нийтийн ашиг сонирхлыг аливаа хууль бус халдлагаас хамгаалах, хөндөгдсөн эрхийг сэргээх эрх хэмжээг хэрэгжүүлдэг бөгөөд Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэхээр заасан. Иймд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал бол шүүх эрх мэдлийг шударгаар хэрэгжүүлэх баталгаа болдог. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, үндсэн хуульт ёс болон хууль дээдлэх зарчмыг хангахад зайлшгүй шаардлагатай суурь үзэл баримтлал болдог тул үүнийг улс орнуудад зарчим гэж хүлээн зөвшөөрч, Үндсэн хуульдаа тусгадаг бөгөөд олон улсын гэрээ, баримт бичигт баталгаажуулсан байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын Ерөнхий Ассамблейгаас 1948 онд баталсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 10 дугаар зүйлд хүн бүр тулгасан аливаа эрүүгийн хэргийг хянан шийдвэрлүүлэх болон эрх, үүргээ тодорхойлуулахдаа бие даасан, тал хардаггүй шүүхээр адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй гэж тунхагласан байна. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 1966 онд баталсан Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14 дүгээр зүйлд шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй, түүнчлэн хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан шийдвэрлүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, бие даасан, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй болохыг тусгажээ.

2.Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчим нь аливаа хүн, хуулийн этгээд эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд хандах, шударгаар шүүлгэх үндсэн эрхийг хангах суурь нөхцөл юм. Өөрөөр хэлбэл, энэхүү зарчим нь эдлэх эрх ямба, давуу байдлыг биш харин ардчилсан нийгмийн шударга ёсны тогтолцоо, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой бөгөөд үндсэн хуульт ёс, Үндсэн хуулиар бэхжүүлсэн төрийн эрх мэдэл хуваарилах, харилцан хяналт, тэнцэлтэй байх үзэл баримтлалын тулгуур мөн (Цэцийн дүгнэлт, 2002, №01; 2004, №01; 2015, №05; Цэцийн тогтоол, 2002, №01; 2016, №05). Нөгөө талаас уг зарчим шүүх, шүүгчид аливаа хэрэг, маргааныг хараат

бус, шударгаар гагцхүү хуульд захирагдан үндэслэлтэй шийдвэрлэх үүрэг хүлээлгэдэг. Тодруулбал, шүүх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхийн тулд эрх бүхий, бие даасан, тал үл харсан (төвийг сахисан) байх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үндсэн үүрэгтэй нь уялдана. Учир нь бусад бүх хамгаалалт үгүй болсон үед ч хүний эрх, эрх чөлөөний эсрэг чиглэсэн аливаа халдлагаас иргэнийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх үүргийг шүүх хүлээдэг болно.

Иймд Үндсэн хуулиар хүн бүр эрх бүхий, бие даасан, тал үл харсан шүүхээр эрх тэгш байх үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй гэсэн суурь зарчмыг тусгаж, зүй бус нөлөөллөөс хамгаалах баталгааг бий болгосон. Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж, 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.” гэж, 3 дахь хэсэгт “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.” гэж тус тус заасан. Эдгээр заалтад “хараат бус байдал”-ыг хувь шүүгчид, харин “бие даасан байдал”-ыг шүүхийн институтэд хамааруулан хэрэглэсэн байна. Шүүхийн бие даасан байдал нь шүүх эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусдаа төрийн эрх мэдлийн салаа гэж үзэх агуулгатай бол шүүгчийн хараат бус байдал нь шүүгчээс шүүн таслах үүргээ хөндлөнгийн нөлөөгүйгээр гагцхүү хуульд захирагдаж хэрэгжүүлэхэд чиглэдэг. Ийнхүү Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Дөчин долдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин есдүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 2, 4 дэх хэсгийн зохицуулалтаар шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчим, түүнийг хангах баталгаа болон хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон бөгөөд энэ нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал мөн.

3.Үндсэн хуулиар баталгаажсан шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах хууль зүй, эдийн засаг, нийгэм болон бусад баталгааг төрөөс бүрдүүлэх үүрэгтэй. Энэ хүрээнд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулсан, дордуулсан хууль тогтоомж, эрх зүйн бусад акт гаргахыг хориглоно. Тодруулбал, шүүгчийг аливаа халдлагаас хуулиар хамгаалах; шүүгчийг тэтгэвэрт гарах хүртэл нь буюу хугацаагүй томилох; шүүгчийн цалингийн хэмжээ хүрэлцээтэй (эдийн засгийн хувьд бусдаас хараат бусаар ажиллаж, амьдрахад нь) байх; шүүгчийн халдашгүй байдлыг хуулиар үр нөлөөтэй хамгаалах; шүүгчийг огцруулах, чөлөөлөх, шилжүүлэх, тэтгэвэрт гаргах нөхцөлийг аливаа дур зоргоос ангид зохицуулах; иргэний эрхээ хязгаарлуулсныг нь нөхөн гүйцээсэн нийгмийн баталгаагаар хангах; шүүгч тасралтгүй сурах, хөгжих боломжийг бий болгох; чиг үүргээ бүтээмжтэй, хариуцлагатай хэрэгжүүлэх



баталгааг бүрдүүлэх зэрэг суурь нөхцөлийг Үндсэн хууль, холбогдох хуулиар бий болгох шаардлага тавигддаг бөгөөд олон улсад дагаж мөрддөг шүүхийн бие даасан байдлын талаарх баримт бичигт эдгээр нь тусгалаа олсон байна.

“Шүүхийн бие даасан байдлын талаарх НҮБ-ын суурь зарчим” (цаашид “НҮБ-ын суурь зарчим” гэх)-ын 1 дэх заалтад “Шүүхийн бие даасан байдлыг төрөөс баталгаажуулж, тухайн улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тусган баталгаажуулна. Шүүхийн бие даасан байдлыг Засгийн газар болон түүний харьяа байгууллагууд хүндэтгэж, сахин биелүүлнэ.” гэж заасан бөгөөд 11 дэх заалтад “Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, тэдний хараат бус байдал, хүрэлцэхүйц хэмжээний цалин, ... болон тэтгэврийн нөхцөл, тэтгэвэрт гаргах насыг хуулиар хамгаална.” гэж, 12 дахь заалтад “Томилогдсон, эсхүл сонгогдсон шүүгч нь тэтгэврийн насанд хүрэх хүртэл, эсхүл бүрэн эрхийн хугацааг дуустал ажиллах баталгаа бүхий байна.” гэж тусгажээ. Мөн “Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим” (цаашид “Бангалорын зарчим” гэх)-д шүүгч нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын зүй бус харилцаа холбоо, нөлөөнөөс ангид байх төдийгүй тэдгээрээс үл хамаарах хөндлөнгийн этгээд байх талаар заасан байдаг. “Бангалорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаарх баримт бичгийн 13.1-д “Шүүгчээс шүүн таслах чиг үүргээ хэрэгжүүлэх бүхий л бололцоог бүрдүүлэх нь төрийн үүрэг юм.”, 13.2-т “Шүүгч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрэх хүртэл, эсхүл хугацаатай томилогддог бөгөөд тухайн бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл ажил, албан тушаал нь хэвээр хадгалагдах үндсэн хуулийн баталгаагаар хангагдана. ...” гэж тусгасан байна.

Мөн Шүүхийн бие даасан байдлын талаарх түгээмэл тунхаглалын (Монреалын тунхаглал) 2.19 дэх хэсгийн а) заалтад “Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, хараат бус, аюулгүй байдал, хангалттай хэмжээний цалин хөлс, ажиллах нөхцөл зэргийг хуулиар тогтоож хамгаалах ба сөрөг үр дагавартайгаар өөрчилж үл болно.” гэж, мөн хэсгийн б) заалтад “Сонгогдсон болон томилогдсон шүүгч нь өндөр насны тэтгэвэрт гарах насанд хүрэх эсхүл тодорхой хугацаатай томилогддог улсын хувьд бүрэн эрхийн хугацаа дуусах хүртэл ажил албан тушаал нь хадгалагдана. ...” гэж заажээ.

Дээр дурдсан баримт бичгүүдэд шүүгчийг зөвхөн мэргэжлийн болон зан байдлын хувьд албан үүргээ хэрэгжүүлж чадахгүй гэх үндэслэлээр бүрэн эрхийг нь дуусгавар болгох арга хэмжээ авч болох ба шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах, албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулахтай холбогдсон аливаа ажиллагааг тогтоосон стандартын дагуу явуулахаар тусгаж, ийнхүү сахилгын шийтгэл оногдуулах шийдвэрийг бие даасан хяналтын байгууллага гаргахаар онцгойлон тусгасан.

Ийнхүү шүүгчийг томилох, түүний бүрэн эрхийг дуусгавар болгох буюу огцруулах, чөлөөлөх, шилжүүлэх, тэтгэвэрт гаргахтай холбоотой асуудлыг улс орнууд Үндсэн хууль болон олон улсын баримт бичигт тусгасан үндсэн зарчимд нийцүүлэн, аливаа дүр зоргоос ангид, хууль ёсны үндэслэл, нөхцөл, журмыг тодорхой хуульчлан тогтоодог нь шүүгчийн хараат бус байдлын суурь баталгаа болдог.

4.Шүүгчийн тэтгэвэрт гарах насыг оновчтой тогтоох нь шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулах чухал хүчин зүйл тул шүүгчийн тэтгэвэрт гарах насыг хэт эрт эсхүл хэт хойно тогтоох, тодорхой хуульчлахгүй байх, хуулиар бус дүрэм, журмаар зохицуулах, хууль ёсны зайлшгүй үндэслэлгүйгээр тэтгэвэрт гарах нөхцөлийг өөрчлөх нь хараат бус байдлыг алдагдуулах эрсдэл үүсгэдэг. Иймд шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгох харилцаа, үүнд хамаарах тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг холбогдох хуульд нарийвчлан хуульчилдаг байна. Судалгаанаас үзэхэд улс бүр өөрийн орны онцлогт нийцүүлж, шүүгчийн хараат бус байдлын зарчимд үндэслэн Үндсэн хууль, холбогдох хуульдаа шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг тодорхой, тогтвортой тогтоох чиг хандлага нийтлэг байна.

5.Монгол Улсын шүүхийн тухай хуулийг түүхчлэн авч үзвэл, 1993, 2002, 2012 оны холбогдох хуульд шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байхаар тогтоож, уг насанд хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох буюу шууд тэтгэвэрт гаргахаар, түүнчлэн 55 насанд хүрсэн эсхүл нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болохоор нийтлэг байдлаар хуульчилж байжээ. Мөн 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт “Шүүгч Хөдөлмөрийн тухай хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөж болно.” гэж зааж байсан бөгөөд уг зохицуулалтын талаарх маргааныг Үндсэн хуулийн цэц 2017 онд хянан хэлэлцээд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчөөгүй гэсэн 05 дугаар дүгнэлт гаргасан байна.

Харин 2021 оны Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ (цаашид “Монгол Улсын шүүхийн тухай хууль” гэх)-ийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж хуульчилсан бөгөөд уг хэсэгт ажилласан жилээр хязгаар тогтоон шууд тэтгэвэрт гаргах зохицуулалтыг шинээр тусгасан байна.



6.Монгол Улс Үндсэн хуульдаа шүүгчийг хуулиар тогтоосон тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл нь хугацаагүй томилох, түүнчлэн бүрэн эрхээ хуулийн дагуу зохих ёсоор гүйцэтгэж байгаа бол огцруулахыг хориглох үзэл баримтлалыг тусгаж, шүүгчийн хараат бус байдлыг баталгаажуулсан. Тодруулбал, Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. ...” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.”, Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэж зааж, шүүгчийг хуульд заасан үндэслэлээр, өөрийнх нь хүсэлтээр чөлөөлөх, эсхүл шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, Шүүхийн сахилгын хорооны шийдвэр гарснаар огцруулахаас бусад тохиолдолд бүрэн эрхийг нь дур мэдэн дуусгавар болгохыг хориглож, бүх шатны шүүгчийг тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл нь хугацаагүй томилохоор зохицуулжээ. Өөрөөр хэлбэл, зөвхөн Үндсэн хуулиар хамгаалсан шүүгчийн хараат бус байдлын зарчимд нийцсэн үндэслэл, журмаар шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгохоор заасан болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт “Шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажуулна.” гэж заасан бөгөөд уг зүйлийн 42.3.1 дэх заалтад Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглосон бол 42.3.3 дахь заалтад шүүгч хугацаагүй томилогдож, захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй, огцрохгүй гэж тусгажээ. Мөн хуулийн шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох талаарх харилцааг зохицуулсан 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэгт “Шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, эсхүл шүүгчээр 25 жил ажилласан бол өөрийн хүсэлтээр өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдөж болно.” гэж заасан бөгөөд тус зүйлийн 40.2.1 дэх заалтад шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан, мөн 40.2.9 дэх заалтад шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийг дуусгавар болгож, чөлөөлөхөөр нарийвчлан хуульчилсан байна. Түүнчлэн шүүгчээр ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарах, тэтгэврээ зохих ёсоор

тогтоолгох, мөн хөдөлмөрийн чадвараа алдсан шүүгчид олгох тэтгэвэр, тэтгэмжийг тогтоох нь шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах нийгэм, эдийн засгийн баталгааг бүрдүүлэх чухал ач холбогдолтойг харгалзан дээрх хуулийн 47 дугаар зүйлд энэ талаарх зохицуулалтыг тусгажээ.

7.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж хуульчилсан зохицуулалтын агуулгыг авч үзвэл (1) шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байхаар нийтлэг байдлаар тогтоож уг насанд хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох буюу шууд тэтгэвэрт гаргах; (2) хэдэн жил ажилласнаас үл хамааран 55 насанд хүрсэн шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх эдлэхээр; (3) шүүгчээр нийт 25 жил ажилласан бол хэдэн настайгаас үл хамааран шүүгч өөрөө хүсвэл мөн өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх эдлэхээр; (4) шүүгчээр 30 ба түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол тэтгэвэр тогтоолгох буюу шууд тэтгэвэрт гаргах эрх зүйн үр дагавартай байна. Дээрх дөрвөн нөхцөлийн хоёр нь шүүгчийн өөрийнх нь хүсэлтээр шийдвэрлэхээр тусгасан бол хоёр нь шүүгчийн ажилласан жил, насыг шалгуур болгон заавал буюу шууд тэтгэвэрт гаргах шаардлагыг тогтоож, тодорхой хязгаарлалт бий болгожээ.

8.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалтад 30 жил шүүгчээр ажилласнаар 60 нас хүрээгүй байсан ч шууд тэтгэвэрт гаргахаар хуульчилсан нь агуулгын хувьд шүүгчийг тодорхой хугацаатайгаар томилох буюу шүүгчийн бүрэн эрхийн хугацаа 30 жил байх утгыг илэрхийлж байна. Ийнхүү шүүгчийг тодорхой хугацаагаар томилох агуулгыг ердийн хуульд тусгасан нь Үндсэн хуулиар баталгаажсан шүүгчийн хараат бус байдлын гол бүрдэл болох шүүгчийг тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл нь хугацаагүй томилох зарчимд нийцээгүй байна.

Тодруулбал, уг зохицуулалт Үндсэн хуулиар болон тус хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтаар бэхжүүлсэн шүүгчийг тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл нь хугацаагүй томилох зарчимд нийцээгүй бөгөөд шүүгчийн хараат бус байдлын баталгааг алдагдуулж, шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулсан байна. Мөн ийнхүү хуульчлах нь цаашдаа энэ мэтээр ажилласан жилийн хязгаарыг багасган тогтоох замаар Үндсэн хуулиар баталгаажуулсан шүүгчийн хараат бус байдалд халдах буруу жишиг тогтоохоор байна. Хууль тогтоогч ийнхүү шинэ хууль гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулах нь шүүгчийн хараат бус байдлын баталгааг явцууруулах, төрийн эрх мэдлийн



харилцан хяналт тэнцлийн зарчмыг сулруулах эрсдэлийг үүсгэж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

9.Үндсэн хуульд заасан “хууль дээдлэх” тухай ойлголт нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаар илэрхийлэгдсэн боловч агуулга, багтаамжийн хувьд ардчилсан, эрх зүйт төрийн үнэт зүйлсийг өргөн агуулгаар хамгаалж, үндсэн хуульт ёс болон хууль дээдлэх ёсны суурь үзэл баримтлалыг өөртөө багтаана (Цэцийн дүгнэлт, 2018, №12; №15; 2019, №02; 2020, №01; №03; №06; 2021, №02; 2024, №03; №04; Цэцийн тогтоол, 2002, №02; 2023, №03; 2024, №02; №03). Үндсэн хуулиар баталгаажсан хууль дээдлэх ёс, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчмын дагуу шүүгчийн эрх зүйн байдлыг хуулиас гадуур хөндөх, хязгаарлахыг хориглох бөгөөд үүнд холбогдох хэм хэмжээг хуульд хэлбэрийн хувьд тусгаснаар энэ зарчим хангагдахгүй, харин түүний үндэслэл, журмыг тодорхой хуульчлах буюу эрх зүйн тодорхой байдлыг хангах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, тухайн хэм хэмжээг хоёрдмол утгагүй, тодорхой, үр дагаврыг урьдчилан таамаглаж, мэдсэнээр зан үйлээ нийцүүлэх боломжтой байдлаар хуульчилбал зохино (Цэцийн дүгнэлт, 2018, №09; №12; 2020, №12; 2021, №02; 2024, №03; №04; 2025, №01; Цэцийн тогтоол, 2022, №02; 2024, №02; №03). Иймд дээрх шалгуураар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг шалгах нь зүйтэй байна:

9.1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэсэн хоёр дахь өгүүлбэр (цаашид “маргаан бүхий зохицуулалт” гэх) нь тус хэсгийн нэг дэх өгүүлбэртэй зарчмын хувьд (уг өгүүлбэрээр тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг тогтоосон бол маргаан бүхий зохицуулалтаар ажиллах хугацааны дээд хязгаар буюу бүрэн эрхийн хугацааг тогтоосон) зөрчилдсөний зэрэгцээ, мөн хуулийн 40 дүгээр зүйлд заасан шүүгч өндөр насны тэтгэвэр тогтоолгож, чөлөөлөгдөх үндэслэлд тусгаагүй нэмэлт шаардлагыг тогтоон, хуулийн бусад зохицуулалттай уялдуулан хэрэгжүүлэх боломжгүй байдлаар хуульчилсан нь хууль хэрэглээний тодорхой бус байдлыг үүсгэсэн байна.

Энэ талаарх Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 01/1185 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлбарт “... Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн энэ зохицуулалтыг хэрхэн ойлгож хэрэглэх асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Уг хуралдаанаар “шүүгч хүсэлт гаргаагүй тохиолдолд шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн гэсэн үндэслэлээр шүүгчийг чөлөөлүүлэхээр өргөн мэдүүлэх боломжгүй” гэж олонхын саналаар шийдвэрлэхдээ дараах

үндэслэлүүдийг баримталсан: а) Хуулийн энэ заалтаар 25-30 хүртэл настайдаа томилогдсон шүүгч нарын бүрэн эрхэд хугацаа тогтоосон байдлаар хэрэгжихээр байгаа нь Шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын шүүгч хугацаагүй томилогдох баталгааг хөндөж байгаа; б) Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн гэсэн хоёр урьдчилсан нөхцөлийн аль нэг нь бий болохгүй тохиолдолд уг заалт хэрэгжих боломжгүй; в) Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийг хүний нөөцөөр хангах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.3 дахь заалтад заасны дагуу шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлүүлэх тухай саналыг Ерөнхийлөгчид хүргүүлэх бүрэн эрхтэй ч энэ нь 42 дугаар зүйлийн 42.3.1 дэх заалтад заасан үндэслэлээр хязгаарлагддаг; г) Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.2-40.2.9 дэх заалтад мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн гэх үндэслэлийг заагаагүй; д) Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэгт “шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн” тохиолдол ороогүй тул мөн зүйлийн 32.2.1 дэх заалтын “... тогтоолгох бол ... Ерөнхий зөвлөлд мэдэгдэх ...” гэдэгт шүүгч, түүний гэр бүлийн гишүүний нийгмийн баталгааны талаарх 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн “... тогтоолгоно ...” гэснийг хамааруулах нь мөн хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.1 болон 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтын “... захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй ... байх,” гэснийг зөрчихөөр байгаа юм.” гэжээ.

9.2.Эрх зүйн тодорхой байдал нь хуулиар юуг зөвшөөрч, хориглох, ямар эрх эдлүүлж, үүрэг хүлээлгэж байгааг мэдэх, хуулийг сахин биелүүлснээр үүсэх үр дагаврыг урьдчилан таамаглах, үүнийхээ үндсэн дээр хүн хувийн амьдралаа төлөвлөж, хэрэгжүүлэх боломж буюу эрх чөлөөний энгийн утгыг баталгаажуулдаг учраас хууль дээдлэх ёсны бүрдэлд багтдаг. Гэтэл Монгол Улсын шүүхийн тухай хуульд 30 жил ажилласан бол 55 насанд хүрснээр тэтгэвэр тогтоолгох зохицуулалтыг тусгасан нь шүүгчийг нийтлэг зохицуулалтын дагуу тэтгэвэр тогтоолгох боломжийг хязгаарлан, тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртлээ тав хүртэл жил ажиллах, улмаар үүнтэй уялдуулан авах тэтгэврийн хэмжээг (нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан жил нэмэгдэх нь тогтоолгох тэтгэврийн хэмжээнд мөн нөлөөлдөг) тодорхойлох хууль ёсны хүлээлт буюу үр дагаврыг урьдчилан таамаглах нөхцөлийг явцууруулж, шууд тэтгэвэрт гарах насыг тав хүртэлх насаар багасгаж, тухайн хугацаанд хамаарах нийгэм, эдийн засгийн баталгаа болон тогтоолгож болох тэтгэврийн хэмжээг мэдэгдэхүйц бууруулах үр дагавартай байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалт нь мөн хуулийн



зарим хэсэг, заалттай зөрчилдөж, хууль хэрэглээний уялдаагүй байдал үүсгэж, шүүгчийн эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгааг дордуулах нөхцөлийг бүрдүүлж, эрх зүйн тодорхой бус байдлыг бий болгосон байна.

10.Иргэн мэдээлэлдээ маргаан бүхий зохицуулалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэж заасныг зөрчсөн эсэхийг тогтоолгох шаардлага тавьсан тул эрх тэгш байх зарчмыг зөрчиж, ялгаварлан гадуурхсан эсэхийг шалгахад дараах үндэслэл тогтоогдож байна:

10.1.Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар тэгш байдал нь төрөөс бүхий л үйл ажиллагаандаа баримтлах үндсэн зарчим юм. Нөгөө талаас Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж хүн бүр эрх тэгш байх зарчмыг баталгаажуулсан. Тус зарчим нь дараах агуулгыг илэрхийлнэ. Нэгд, хүн бүрийг эрх зүйн этгээд гэж хүлээн зөвшөөрч, хүний нэр төрийг нь хүндэлнэ (Цэцийн дүгнэлт, 2025, №01). Энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж туссан. Хоёрт, хуулийн агуулга, хэрэгжилт, хэрэглээ эсхүл бусад үйл ажиллагаанд хэнийг ч дорд үзэж, ялгаварлан гадуурхаж болохгүй. Энэ утгыг Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэж тодруулсан бөгөөд энд дурдсан эсхүл дурдагдаагүй шинж (хөгжлийн бэрхшээл зэрэг)-ээр нь ялгаварлан гадуурхаж болохгүй (Цэцийн дүгнэлт, 2017, №07). Гуравт, хүн бүр эрхийнхээ хувьд тэгш байх бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээг төрөөс авна. Тухайлбал, хүйс үл хамааран тэгш эрх эдлэхийг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалтад “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална,” гэж тусгайлан заажээ. Дөрөвт, ялгаварлан гадуурхахад хүргэх шалтгаан болсон ужиг нөхцөлийг арилгах, бууруулах зорилгоор хүн амын тодорхой хэсэгт давуу хандсан тусгай арга хэмжээ авах нь эрх тэгш байх зарчмыг хөндөхгүй. Тодруулбал, ийм нөхцөлийн улмаас хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлж чадахгүй байгаа хүмүүст давуу байдал олгож болох бөгөөд зорилго нь биелмэгц тус арга хэмжээг зогсооно. Тавд, үндсэн эрхийг эдлүүлэх болон бусад хүрээнд хүмүүст дур мэдэн буюу зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандахыг хориглоно.

Эрх тэгш байх зарчим нь хүн бүрд бүх талаар адил хандах утгыг илэрхийлэхгүй бөгөөд адил нөхцөлд байгаа хүмүүст адил хандах, харин ялгаатай нөхцөлд байгаа хүмүүст ялгаатай хандах агуулгатай. Мөн тэгш байдлын зарчим бол ижил эрх зүйн байдалтай этгээдүүдийн хувьд тодорхойлогдох ойлголт болно (Цэцийн дүгнэлт, 2014, №06; 2018, №12; 2021, №06; 2024, №01; Цэцийн тогтоол, 2007, №02; 2019, №03). Иймд эрх тэгш байх зарчмын дагуу хуулиар болон хуулийг хэрэгжүүлэхдээ хүнд дур мэдэн тэгш бус хандахыг хориглох бөгөөд хэрэв хуулиар Үндсэн хуульд заасан үндэслэлээс гадуур ялгаварлаж хандсан бол эрх тэгш байх зарчмыг зөрчсөн гэж үзнэ.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн эхний өгүүлбэрээр шүүгч 60 насанд хүрснээр шууд тэтгэвэрт гаргах буюу шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдөх үндэслэлийг тодорхойлсон бол маргаан бүхий зохицуулалтаар 30 жил шүүгчээр ажилласан бол 60 нас хүрээгүй байхад шууд тэтгэвэрт гаргах үр дагавартай байхаар хуульчилсан байна. Үүнээс үзэхэд 25-29 насандаа шүүгчээр томилогдож, 30 жил ажилласан шүүгч 55 насанд хүрснээр шууд тэтгэвэрт гаргах шаардлагыг тогтоосон бол 30-аас дээш насандаа шүүгчээр томилогдсон шүүгч хэдэн жил шүүгчээр ажилласнаас үл хамааран 60 насанд хүрснээр тэтгэвэр тогтоолгохоор хуульчилж шүүгчийг томилсон нас, ажилласан жилээр ялгаварласан байна. Энэ нь ижил эрх зүйн байдалтай, адил чиг үүрэг хэрэгжүүлж байгаа шүүгч нарыг ажилласан жил, шүүгчээр томилогдсон насаар нь зохих үндэслэлгүйгээр ялгаварлаж, эрх зүйн байдлыг дордуулан тэтгэвэр тогтоолгох нөхцөлийг бүрдүүлж эрх тэгш байх зарчмыг зөрчсөн байна.

10.2. Монгол Улсын шүүхийн тухай хуульд зааснаар хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, шүүгчид тавигдах болзол, шаардлага хангасан хуульч хуульд заасан шалгалтад тэнцэж, шүүгчээр томилогдсон тохиолдолд шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Мөн дээрх зөвшөөрлийг авсны үндсэн дээр тусгай шалгаруулалтад орж тэнцсэнээр өмгөөлөгч, прокуророор ажиллах бөгөөд холбогдох хуульд зааснаар өмгөөлөгч, прокурор, шүүгч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг, түүнийг хэрэгжүүлэхэд оролцдог эрх бүхий субъект болно. Иймд тэдгээрийн тэтгэвэрт гарах нас, ажилласан жилийн дээд хязгаарыг тогтоосон зохицуулалтыг харьцуулан үзэхэд Прокурорын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт “Прокурорын тэтгэвэрт гарах насны дээд хязгаар нь 60 нас байх ба 50 насанд хүрсэн эмэгтэй, 55 насанд хүрсэн эрэгтэй, эсхүл нас харгалзахгүйгээр прокуророор 25 жил ажилласан прокурор өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно.” гэж зааж, ажилласан жилийн дээд хязгаарыг тогтоогоогүй байна. Харин Өмгөөллийн тухай хуулиар өмгөөлөгчийн тэтгэвэрт гаргах харилцааг зохицуулаагүй байх тул Нийгмийн



даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн нийтлэг зохицуулалтыг баримтлах бөгөөд хамгийн багадаа тэтгэврийн даатгалын шимтгэлийг 25-аас доошгүй жил төлсөн 60 насанд хүрсэн эрэгтэй, 55 насанд хүрсэн эмэгтэй өмгөөлөгчид өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх үүсэхээр байна. Үүнээс үзэхэд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалтаар 30 жил ажилласан шүүгчийн заавал тэтгэвэрт гарах насыг 55 байхаар багасган хуульчилсан нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг субъектүүдийн хувьд зохих үндэслэлгүй ялгаварласан зохицуулалт болжээ.

11.Тохирсон байх зарчмын дагуу шүүгчийн эрх зүйн байдлыг хөндсөн зохицуулалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангах ёстой (Цэцийн дүгнэлт, 2024, №03; №04; 2025, №01; Цэцийн тогтоол, 2024, №02; №03). Иймд дээрх зохицуулалтыг эдгээр шалгуурыг хангасан эсэхийг шалгахад дараах үндэслэл тогтоогдож байна:

11.1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа хууль тогтоогч шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилт тавьсан гэж үзэж болно. Тодруулбал, тус хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, шүүгчийн бүрэн эрх, эрх зүйн байдал, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заагаад, уг хуулийн Аравдугаар бүлэгт шүүгчийн хараат бус байдал, түүнийг хангах баталгааг хуульчилж, уг бүлгийн 47 дугаар зүйлээр шүүгч, түүний гэр бүлийн гишүүний нийгмийн баталгаанд холбогдох харилцааг зохицуулсан нь шүүгчийн хараат бус байдлыг хангахад чиглэсэн хууль ёсны зорилготой байна.

Гэсэн хэдий ч дээрх хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалтад тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрээгүй байхад нь шууд тэтгэвэрт гаргах нөхцөл, шаардлагыг нийтлэг заалтаас өөрөөр тогтоож, түүнчлэн шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг бус ажиллах жилийн дээд хязгаарыг тогтоосон агуулгатай байгаа нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зорилт болон тус хуулийн төслийн үзэл баримтлалд тодорхойлсон агуулгад нийцээгүй байна.

Харин Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлд тусгаснаар дээрх зохицуулалт нь Улсын Их Хурлын гишүүний

саналаар нэмэгдсэн байх ба тухайн гишүүн саналын үндэслэлээ “нэг ажилд хэт удах дэмий” гэж тайлбарласан байна (2021.01.05, х.220). Мөн Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт уг зохицуулалтын зорилгыг шүүх эрх мэдлийн шинэтгэл, залгамж чанарыг тэнцвэржүүлэх, шинэ томилгоо хийх боломжийг бүрдүүлэх (ротаци хийх)-д чиглэгдсэн гэж тусгасан байна.

11.2.Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарын хүрээнд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалт нь шүүх эрх мэдлийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тодорхойлсон шүүх бүрэлдэхүүн, түүний зохист насны бүтцийг бий болгох зэрэг зорилгод хүрэхэд чиглэсэн байж болох хэдий ч зайлшгүй бус байна. Тухайлбал, мөн зүйлийн 47.6 дахь хэсэгт “Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 60 нас байх ба 55 насанд хүрсэн, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. ...” гэж зааж шүүгч 60 нас хүрснээр тэтгэвэрт заавал гарахаар хуульчилсан нь энэ зорилгод хүрэхэд чиглэсэн, адилхан үр нөлөөтэй зохицуулалт байна. Харин маргаан бүхий зохицуулалт нь шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулж, хараат бус байдлын баталгааг алдагдуулж байгаагаараа түүнийг хуульчилсан зорилгод хүрэхийн тулд авч болох боломжит, үр дүнтэй, зайлшгүй байх шаардлагад нийцээгүй, шүүгчийн эрх зүйн байдлыг хамгийн бага хөндсөн хэм хэмжээ биш байна. Тодруулбал, шүүгчийн тэтгэвэрт гарах насны дээд хязгаарыг тогтоосон атлаа ажилласан жилийн хязгаарыг насны шалгууртай уялдуулан давхар тогтоосон нь хуулийн зорилгыг хангах Үндсэн хуульд нийцсэн зохистой аргад тооцогдохгүй болно.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3.3 дахь заалтаар Үндсэн хуульд заасан шүүгч хугацаагүй буюу тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл томилох зарчмыг бататган хуульчилсан атал маргаан бүхий зохицуулалтаар уг зарчмыг алдагдуулж, 30 жилийн бүрэн эрхийн хугацаагаар шүүгчийг томилох агуулгыг хуульчилсан байх тул энэхүү зохицуулалтаар хангагдах ашиг сонирхол нь шүүгчийн хараат бус байдлын зарчмаас илүү ач холбогдолтой биш байна. Иймд тэнцвэртэй байх шалгуурыг хангаагүй байна. Өөрөөр хэлбэл, уг зохицуулалт нь ардчилсан, эрх зүйт төрийн үндсэн зарчмын салшгүй бүрдэл хэсэг болох шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын зарчим, түүгээр нөхцөлдөн хамгаалагдсан шүүхэд хандах, шударга шүүхээр шүүлгэх иргэний үндсэн эрхийн баталгааг дордуулах нөлөөтэй байх тул шударга ёс, хууль дээдлэх зарчмын үүднээс зөвтгөгдөх үндэслэлгүй байна.

12.Хэдийгээр манай улсад 30-35 насандаа шүүгчээр томилогдох нийтлэг хандлагатай байгаа өнөөгийн нөхцөлд 25-30 жил ажиллаж, тэтгэвэрт гарах насны дээд хязгаар болох 60 насанд хүрснээр шууд



тэтгэвэрт гарах бодит нөхцөл байдал байгаа ч хууль тогтоогч ийнхүү ижил эрх зүйн байдал бүхий шүүгч нарт зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандсан хэм хэмжээг хуульчлах замаар шүүгчийн хараат бус байдлын баталгааг алдагдуулах буруу жишиг тогтоох, шүүгчийн эрх зүйн байдлыг дордуулах сөрөг үр дагавартай байгааг онцлон тэмдэглэж байна.

13.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг нь шүүгчийн тэтгэвэр тогтоолгох үндэслэл, нөхцөлийг тодорхойлсон, шүүгчийн нийгмийн баталгааг хангахад чиглэсэн хэм хэмжээ байх тул Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалтад заасан хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, өндөр наслах, хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах иргэний үндсэн эрхийг зөрчсөн агуулгагүй байна.

14.Нэгтгэн дүгнэхэд,

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт "... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно." гэж заасан нь шүүгчийг 30 жилийн хугацаагаар томилох агуулгыг илэрхийлж, 25-29 насандаа шүүгчээр томилогдон, 30 жил ажилласан шүүгч 55 насанд хүрснээр тэтгэвэр тогтоолгох буюу шууд тэтгэвэрт гаргах үр дагаврыг үүсгэсэн байна. Ийнхүү хуульчилснаар эрх зүйн тодорхой бус байдлыг үүсгэсэн, 25-29 насандаа томилогдсон шүүгч нарыг ажилласан жил, шүүгчээр томилогдсон насаар нь ялгаварлан шууд тэтгэвэрт гаргаж, бүрэн эрхийн хугацааг эрт дуусгавар болгох хууль зүйн нөхцөлийг бүрдүүлж, ижил эрх зүйн байдалтай адил чиг үүрэг хэрэгжүүлж байгаа шүүгч нарт зохих үндэслэлгүйгээр тэгш бус нөхцөлийг тогтоосон, тохирсон байх зарчмын гол шалгуур болох хууль ёсны зорилгодоо хүрэхэд зайлшгүй, тэнцвэртэй байх шалгуурт нийцэхгүй байна. Энэ нь Үндсэн хуулиар баталгаажсан шударга ёс, хууль дээдлэх, эрх тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчимд нийцээгүй байх бөгөөд шүүгчийн хараат бус байдлын баталгаа болон шүүгчийг тэтгэвэрт гарах насны дээд хязгаар хүртэл нь хугацаагүй томилох зарчмыг алдагдуулсан байна.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... нас ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс ... нийгэм, хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.", Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Үндсэн

хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн байна.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дээрх зохицуулалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах ... эрхтэй. ...”, мөн зүйлийн 5 дахь заалтад “өндөр наслах ... тохиолдолд ... тусламж авах эрхтэй;” гэснийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

15. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон байна. Иймд Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлт гарсан цагаасаа хойш (ex nunc) үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартайг тэмдэглэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... хууль дээдлэх ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... нас ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс ... нийгэм, хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Тавин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийн 1 дэх хэсэгт заасан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсгийн холбогдох зохицуулалт



Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтад “... хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах ... эрхтэй. ...”, мөн зүйлийн 5 дахь заалтад “өндөр наслах ... тохиолдолд ... тусламж авах эрхтэй,” гэснийг зөрчөөгүй байна.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт “... Шүүгчээр 30, түүнээс дээш жил ажилласан бөгөөд 55 насанд хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоно.” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Г.БАЯСГАЛАН

ГИШҮҮД

Д.ГАНГАБААТАР

О.МӨНХСАЙХАН

Э.ЭНХТУЯА

Р.БАТРАГЧАА

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003